



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/385

Арвайхээр

Хөрөнгө шийдвэрлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх журам батлах тухай” 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дөрвөн удаагийн дуудлага худалдаанд ороод худалдагдаагүй нэр бүхий 4 хөрөнгийг акталж, хоёрдогч түүхий эд болгон худалдахыг хавсралтаар баталсугай.

2. Хөрөнгө данснаас хасах тээврийн хэрэгслүүдийг “Авто тээврийн үндэсний төв” болон Татварын хэлтсийн бүртгэлээс хасуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, орлогыг “Орон нутгийн өмч худалдсаны орлого” дансанд төвлөрүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




А.ИШДОРЖ

011100822

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны 08  
дугаар сарын 18-ны өдрийн 4/325 дугаар  
захирамжийн хавсралт



АКТАЛЖ, ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭД БОЛГОН ХУДАЛДАХ ХӨРӨНГӨ

Д/д	Байгууллага, хөрөнгийн нэр	Улсын дугаар	Хөрөнгийн				Балансын үнэ	Хуримт- лагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Хоёрдогч түүхий эд болгон худалдах үнэ
			Үйлдвэрлэсэн он	Ашиглал- тад орсон он	Арлын дугаар	Моторын дугаар				
1	Аймгийн Цагдаагийн газрын Королла Аксио маркийн автомашин	73-27 ӨВР	2007	2016	NZE1446005552	-	8,191,500	6,826,250	1,365,250	300,000
2	Арвайхээр сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ Киа маркийн автомашин	51-54 ӨВА	2014	2016	KN3JAX5S1TK07 6358	C-3200	23,000,000	19,166,667	3,833,333	500,000
3	Аймгийн Гэр Бүл хүний хөгжлийн Төв Тоёота Succeed маркийн автомашин	50-56 ӨВР	2003	2012	NCP510048422	-	8,800,00	8,800,000	0	300,000
4	Онги Ус Суваг ХХК Прадо маркийн автомашин	33-75 ӨВР	1998	2011	KZJ780019471	-	17,000,000	17,000,000	0	500,000